

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ,**

**ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Энэ журмын /цаашид “Журам” гэх/ зорилго нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн /цаашид “компани” гэх/ хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ болон “Монголын Хөрөнгийн Бирж” ХК /цаашид “хөрөнгийн бирж” гэх/-д хүргүүлэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Компани нь Журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зарыг хүргэж зохион байгуулна.

**ХОЁР. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ**

- 2.1 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь компанийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацаанд зарлан хуралдуулна.
- 2.2 Компанийн тухай хуульд заасан хурал зарлах эрх бүхий этгээд нь шаардлагатай тохиолдолд компанийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.
- 2.3 Хурал хуралдуулах тухай шийдвэрт Компанийн тухай хуулийн 60.2-т заасан зүйлийг заавал тусгах ба хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 2.4 Хурлаар компанийн тухай хуулийн 63.10-т заасны дагуу хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй.
- 2.5 Хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш Компанийн тухай хуулийн 66.9-т заасны дагуу хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 2.6 Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад бусад гэсэн хэсэг байх шаардлагатай бол энэ нь зөвхөн Компанийн тухай хуулийн 62.1-д заасан асуудал байх бөгөөд эдгээрээс бусад асуудлыг энэ хэсэгт оруулахгүй.
- 2.7 Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг Компанийн тухай хуулийн 64.2-т заасны дагуу хурал зарлагч этгээд тогтоох бөгөөд энэ өдөр нь Журмын 3.5-д заасны дагуу хурал хуралдуулах зарыг нийтэд мэдээллэсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр байхаар тогтоно.
- 2.8 Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцно.
- 2.9 Компанийн тухай хуулийн 64.7, 68.5-д заасантай нийцүүлж, ТУЗ бүртгэх өдрөөс хойш хувьцаа худалдан авсан этгээдийг хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

- 2.10 Хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаснаас хойш 3 хоногийн дотор хурлын мэдэгдэл болон шаардлагатай баримт, материалыг МХБ болон СЗХ-нд хүргүүлнэ.

#### ГУРАВ. ХУРЛЫН ЗАРЫГ ХҮРГЭХ

- 3.1 Компанийн тухай хуулийн 60.4-т заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг гарснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг нийтэд мэдээлнэ.
- 3.2 Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хурал хуралдахаас 30 болон түүнээс багагүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчиддээ мэдээлэх бөгөөд эдгээрээс бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж болно.
- 3.3 Журмын 3.2-т заасан мэдээг зарласан өдрөөс хойш 15 хоногийн дараа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр анх мэдээллэсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.
- 3.4 Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг Журмын 3.2-т заасан утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчдэд хүргэж болно.
- 3.5 Хурал зарлагч этгээд нь Журмын 2.7-д заасан хурлын зарыг нийтэд мэдээллэсэн өдөр гэдгийг хөрөнгийн биржийн цахим хуудсаар нийтэд хүргэсэн өдрийг тооцно.
- 3.6 Хурлын зард дараах мэдээллийг заавал тусгана.
  - 3.6.1 Компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг;
  - 3.6.2 Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
  - 3.6.3 Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
  - 3.6.4 Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг;
  - 3.6.5 Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;
  - 3.6.6 Компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
- 3.7 Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган хурлыг хойшлуулна. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг холбогдох материалын хамт Хороо, хөрөнгийн биржид ажлын 4 хоногт багтаан хүргүүлнэ.
- 3.8 Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.6-т заасантай нийцүүлж, ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын 7-оос доошгүй хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг Журмын 3.2-т заасан хэлбэрийн дагуу дахин мэдээллэнэ.



**ДӨРӨВ.БУСАД**

- 4.1 Энэхүү журмын хэрэгжилтийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хангаж ажиллах бөгөөд хэрэгжилтэд ТУЗ-ийн дарга хяналт тавина.
- 4.2 Хурлыг компанийн ерөнхий захиргаа байрлаж байгаа газраас өөр газарт хуралдуулахаар товлосон бол хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн хамгийн их төвлөрөлтэй, аливаа зардал, чирэгдэлгүйгээр оролцох боломжтой газарт хурлыг хуралдуулна.
- 4.3 Хуралд оролцоогүй, эсхүл эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь хурал зарлагч этгээдийг Компаний тухай хуулийн 66.9 болон энэ Журмын 3.1-3.3, 3.6-д заасныг зөрчсөн гэж үзвэл Хороонд гомдол гаргаж болно.
- 4.4 Энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд заасны дагуу зохицуулна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК